



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/148/НА-СТА-ТШЗ

Цахим  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улиастай сум  
2024 он

хуудас:

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Аудитор : Г.Уранбаяр

Утас:95183025

Цахим хаяг:[gonchigdorjuranbayr@gmail.com](mailto:gonchigdorjuranbayr@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

|                                                                             |                   |
|-----------------------------------------------------------------------------|-------------------|
| 1. Хараат бус аудиторын дүгнэлт .....                                       | 3                 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                  | 4                 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                            | 4                 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                         | <a href="#">4</a> |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....              | <a href="#">5</a> |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                             | <a href="#">6</a> |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                          | <a href="#">7</a> |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....                                     | 8                 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....                                 | 8                 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....                                  | 10                |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....                              | 10                |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..... | 11                |
| 4. Аудитын тайлан.....                                                      | 13                |
| 4.1 Ерөнхий зүйл .....                                                      | 13                |
| 4.2 Материаллаг байдал .....                                                | 14                |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....                                | 14                |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....  | 14                |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                | 15                |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                               | 16                |
| 5. Аудитын илрүүлэлт .....                                                  | 16                |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....                        | <b>16</b>         |

---

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 170

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

УЛИАСТАЙ СУМЫН ХОТ ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА  
А.ГАНТӨМӨР-Т

### Дүгнэлт өгөхөөс татгалзсан

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөсөн.

Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

### Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл

Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний алба нь Төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад тайлангаа бүртгүүлж, баримтаа хүргүүлээгүй, санхүүгийн тайлан гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, авлага өглөгийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулаагүй, хөрөнгийн тооллого хийж, үр дүнг тооцоогүй, тээврийн хэрэгслийн сэлбэгийг техникийн комиссын дүгнэлт гаргалгүйгээр худалдан авдаг, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд гэрээ дүгнэсэн баримт, ажлын тайлан, акт үйлдээгүй, жолоочийн тооцооны хуудас болон тооцоо бодсон баримт байхгүй, байгууллагын данс, улсын бүртгэлд бүртгэлгүй тээврийн хэрэгсэлд шатахуун зарцуулсан, бараа материал үндсэн хөрөнгийн ангилал, ашиглах хугацааг холбогдох стандарт, хууль журамд үндэслэн тодорхойлдоггүй, урсгал засварын зардалд бичигдэх дүнг хөрөнгийн дансанд капиталжуулсан, албан хаагчдад гарын бэлэг авч өгсөн, спортын арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулсан, албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг тушаал, шийдвэргүйгээр бодож олгосон, бараа материалын тайлан гаргадаггүй, анхан шатны баримт эмх цэгцгүй, бүрдэл хангаагүй санхүүгийн баримтаар гүйлгээ хийсэн, өөрийн орлогыг тулган баталгаажуулах нотлох баримт дутуу, байгууллагын дотоод хяналт сул зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д

Audit(D)Дүгнэлт/2024

"жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ", Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1.5-д "өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт" гэж заасныг зөрчиж, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| SORT_ID | Үзүүлэлт                          | ҮЛДЭГДЭЛ         | ГҮЙЦЭТГЭЛ        |
|---------|-----------------------------------|------------------|------------------|
| 1       | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН           | 74,170,901.58    | 92,983,095.88    |
| 2       | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 7,313,855.30     | 2,741,609.83     |
| 8       | Банкинд байгаа бэлэн мөнгө        | 5,413,155.30     | 2,060,078.61     |
| 9       | Төгрөг                            | 5,413,155.30     | 2,060,078.61     |
| 12      | Арилжааны банкин дахь харилцах    | 3,839,328.00     | 2,038,629.63     |
| 15      | Нэмэлт санхүүжилт арилжааны банк  | 1,573,827.30     | 21,448.98        |
| 22      | Богино хугацаат хадгаламж         | 1,900,700.00     | 681,531.22       |
| 27      | АВЛАГА                            | 23,035,405.55    | 34,069,497.55    |
| 28      | Ажиллагсадтай холбогдсон авлага   | -                | 1,091,196.00     |
| 34      | Бусад авлага                      | 23,035,405.55    | 32,978,301.55    |
| 35      | Байгууллагаас авах авлага         | 9,501,112.55     | 10,973,012.55    |
| 36      | Хувь хүмүүсээс авах авлага        | 13,534,293.00    | 22,005,289.00    |
| 60      | БАРАА МАТЕРИАЛ                    | 43,341,040.73    | 56,171,988.50    |
| 61      | Түүхий эд материал                | -                | 480,000.00       |
| 62      | Тусгай зориулалттай материал      | -                | 480,000.00       |
| 64      | Дуусаагүй үйлдвэрлэл              | -                | 165,000.00       |
| 65      | Бэлэн бүтээгдэхүүн                | 916,610.00       | 889,110.00       |
| 66      | Хангамжийн материал               | 42,424,430.73    | 54,637,878.50    |
| 67      | Бичиг хэргийн материал            | 983,600.00       | 1,536,100.00     |
| 68      | Аж ахуйн материал                 | 34,296,830.73    | 31,515,278.50    |
| 69      | Сэлбэг хэрэгсэл                   | 980,000.00       | 5,607,500.00     |
| 70      | Түлш шатах тослох материал        | 22,000.00        | 22,000.00        |
| 71      | Барилгын засварын материал        | 286,000.00       | 286,000.00       |
| 73      | Бусад хангамжийн материал         | 5,856,000.00     | 15,671,000.00    |
| 86      | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН       | 522,421,066.39   | 1,179,160,391.35 |
| 106     | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                    | 522,421,066.39   | 1,179,160,391.35 |
| 108     | Биет хөрөнгө                      | 499,399,066.41   | 1,156,248,391.41 |
| 109     | Барилга, байгууламж               | 369,089,200.47   | 892,189,160.47   |
| 110     | Хуримтлагдсан элэгдэл             | (211,048,599.61) | (272,277,486.81) |
| 111     | Авто тээврийн хэрэгсэл            | 674,075,945.00   | 711,875,945.00   |
| 112     | Хуримтлагдсан элэгдэл             | (643,319,278.09) | (660,159,278.25) |
| 113     | Машин, тоног төхөөрөмж            | 106,364,280.00   | 218,380,402.00   |
| 114     | Хуримтлагдсан элэгдэл             | (83,414,727.54)  | (89,171,049.06)  |
| 115     | Тавилга, аж ахуйн эд хогшил       | 55,589,538.00    | 55,589,538.00    |
| 116     | Хуримтлагдсан элэгдэл             | (53,074,754.92)  | (53,760,604.96)  |
| 122     | Бусад үндсэн хөрөнгө              | 883,463,347.00   | 1,022,821,347.00 |
| 123     | Хуримтлагдсан элэгдэл             | (598,325,883.90) | (669,239,581.98) |
| 126     | Биет бус хөрөнгө                  | 23,021,999.98    | 22,911,999.94    |
| 127     | Програм хангамж                   | 930,000.00       | 930,000.00       |
| 128     | Хасагдуулга                       | (435,000.02)     | (545,000.06)     |

|     |                                                          |                 |                  |
|-----|----------------------------------------------------------|-----------------|------------------|
| 129 | Бусад биет бус хөрөнгө                                   | 22,527,000.00   | 22,527,000.00    |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН                                       | 596,591,967.97  | 1,272,143,487.23 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН                                    | 15,982,256.87   | 280,508,593.67   |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                                | 15,982,256.87   | 280,508,593.67   |
| 164 | Өглөг                                                    | 15,982,256.87   | 280,508,593.67   |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг                           | 8,480,969.63    | 21,742,614.48    |
| 170 | Бусад өглөг                                              | 7,501,287.24    | 258,765,979.19   |
| 171 | Байгууллагад төлөх өглөг                                 | 7,030,300.24    | 258,765,979.19   |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН                                 | 580,609,711.10  | 991,634,893.56   |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо                              | 580,609,711.10  | 991,634,893.56   |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 607,062,429.10  | 607,062,429.10   |
| 217 | Өмч: -Төрийн өмч                                         | 607,062,429.10  | 607,062,429.10   |
| 223 | Хуримтлагдсан үр дүн                                     | (63,233,575.99) | 347,791,606.47   |
| 224 | Өмнөх үеийн үр дүн                                       | (63,233,575.99) | (63,233,575.99)  |
| 225 | Тайлант үеийн үр дүн                                     | -               | 411,025,182.46   |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                         | 36,780,857.99   | 36,780,857.99    |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН                      | 596,591,967.97  | 1,272,143,487.23 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| SORT_ID | ITEM_NAME                                                            | ГҮЙЦЭТГЭЛ      | ГҮЙЦЭТГЭЛ        |
|---------|----------------------------------------------------------------------|----------------|------------------|
| 1       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                                      | 926,745,972.01 | 1,873,265,061.54 |
| 76      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                                  | 326,891,372.01 | 603,319,361.54   |
| 77      | Нийтлэг татварын бус орлого                                          | 306,519,572.01 | 603,319,361.54   |
| 78      | Хүүгийн орлого                                                       | -              | 145,068.32       |
| 81      | Төсөвт байгууллагын өөрийн орлого                                    | 278,019,572.01 | 500,492,493.22   |
| 82      | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 151,902,293.01 | 192,624,211.22   |
| 83      | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 3,094,079.00   | 2,652,000.00     |
| 86      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                    | 123,023,200.00 | 305,216,282.00   |
| 92      | Бусад орлого                                                         | 28,500,000.00  | 102,681,800.00   |
| 111     | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                        | 599,854,600.00 | 1,269,945,700.00 |
| 129     | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       | 599,854,600.00 | 1,269,945,700.00 |
| 130     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 599,854,600.00 | 1,269,945,700.00 |
| 147     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)                                     | 983,698,961.68 | 1,462,239,879.08 |
| 148     | УРСГАЛ ЗАРДАЛ                                                        | 983,698,961.68 | 1,462,239,879.08 |
| 149     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 859,335,646.68 | 1,401,579,779.08 |
| 170     | Хангамж, бараа материалын зардал                                     | -              | 7,269,720.00     |
| 178     | Бараа материал актасны зардал                                        | -              | 7,269,720.00     |
| 194     | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж              | 704,970,618.18 | 1,238,775,302.04 |
| 195     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 704,970,618.18 | 1,238,775,302.04 |
| 209     | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 154,365,028.50 | 155,534,757.04   |
| 212     | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 154,365,028.50 | 155,534,757.04   |
| 224     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                     | 124,363,315.00 | 60,660,100.00    |
| 242     | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 124,620,000.00 | 60,660,100.00    |

|     |                                   |                 |                |
|-----|-----------------------------------|-----------------|----------------|
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг             | 124,620,000.00  | 60,660,100.00  |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (56,952,989.67) | 411,025,182.46 |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)          | (56,952,989.67) | 411,025,182.46 |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| SORT_ID | ITEM_NAME                                                             | ГҮЙЦЭТГЭЛ      | ГҮЙЦЭТГЭЛ        |
|---------|-----------------------------------------------------------------------|----------------|------------------|
| 1       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                                | 794,622,302.01 | 1,558,137,683.54 |
| 77      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                                   | 194,767,702.01 | 288,191,983.54   |
| 78      | Нийтлэг татварын бус орлого                                           | 174,395,902.01 | 288,191,983.54   |
| 80      | Хүүгийн орлого                                                        | -              | 145,068.32       |
| 82      | Төсөвт байгууллагын өөрийн орлого                                     | 145,895,902.01 | 185,365,115.22   |
| 83      | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                             | 142,761,623.01 | 182,713,115.22   |
| 84      | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                             | 3,134,279.00   | 2,652,000.00     |
| 92      | Бусад орлого                                                          | 28,500,000.00  | 102,681,800.00   |
| 110     | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                         | 599,854,600.00 | 1,269,945,700.00 |
| 129     | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                        | 599,854,600.00 | 1,269,945,700.00 |
| 130     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/   | 599,854,600.00 | 1,269,945,700.00 |
| 147     | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)                                | 790,790,407.54 | 1,274,632,129.01 |
| 148     | УРСГАЛ ЗАРДАЛ                                                         | 790,790,407.54 | 1,274,632,129.01 |
| 149     | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                        | 666,170,407.54 | 1,213,972,029.01 |
| 194     | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж              | 666,170,407.54 | 1,213,972,029.01 |
| 195     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 666,170,407.54 | 1,213,972,029.01 |
| 221     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                      | 124,620,000.00 | 60,660,100.00    |
| 239     | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт  | 124,620,000.00 | 60,660,100.00    |
| 242     | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                 | 124,620,000.00 | 60,660,100.00    |
| 250     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)                   | 3,831,894.47   | 283,505,554.53   |
| 261     | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                             | 1,100,000.00   | 288,077,800.00   |
| 262     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                                      | 1,100,000.00   | 288,077,800.00   |
| 263     | Дотоод эх үүсвэрээр                                                   | 1,100,000.00   | 288,077,800.00   |
| 275     | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                        | 1,100,000.00   | 288,077,800.00   |
| 278     | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)                 | (1,100,000.00) | (288,077,800.00) |
| 303     | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                                             | 2,731,894.47   | (4,572,245.47)   |
| 304     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                      | 5,341,960.83   | 7,313,855.30     |
| 305     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                     | 7,313,855.30   | 2,741,609.83     |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ                             | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--------------------------------------|---------------------------------|-----------------------|----------------------|----------------------------------------|
| ДАНС                                 | 511                             | 51300                 | 51210+51220          |                                        |
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 607,062,429                     | 36,780,858            | (63,233,576)         | 580,609,711                            |

|                                            |             |            |              |             |
|--------------------------------------------|-------------|------------|--------------|-------------|
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл       | 607,062,429 | 36,780,858 | (63,233,576) | 580,609,711 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 607,062,429 | 36,780,858 | (63,233,576) | 580,609,711 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0           | 0          | 411,025,182  | 411,025,182 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл       | 607,062,429 | 36,780,858 | 347,791,606  | 991,634,894 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний алба нь: Улиастай сумын орчны тохижилтийг стандартын дагуу цэвэрхэн тохилог байлгах зорилго тавин ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:***

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Хөгжимт жүжгийн театрын даргын дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний алба нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 486,777.20 мянган төгрөгөөр буюу 33,6 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл    | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт            |
|----------------------------------------------|-------------------|---------------------|---------------------|
| Б                                            | 1                 | 2                   | 3=2-1               |
| Бараа материал                               | 43,341.00         | 56,171.90           | (12,830.90)         |
| Үндсэн хөрөнгө                               | 522,421.00        | 1,179,160.30        | (656,739.30)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>596,591.90</b> | <b>1,272,143.40</b> | <b>(675,551.50)</b> |
| Өр төлбөр                                    | 15,982.20         | 280,508.50          | (264,526.30)        |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 580,609.70        | 991,634.80          | (411,025.10)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>596,591.90</b> | <b>1,272,143.40</b> | <b>(675,551.50)</b> |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд

Бараа материал эхний үлдэгдэл 43,341.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 81,364.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй 385,828.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулсан 30,682.7 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 56,171.9 мянган төгрөг болж өмнөх оноос 12,830.9 мянган төгрөгөөр өсөж, акталж устгасан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр 30,376,7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 619,890.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, жилийн эцэст 1,179,160.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 155,534.4 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 675,551.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,269,945.7 мянган төгрөг, өөрийн орлогоос 288,191.9 мянган төгрөгийн зарлагыг

тооцон нийт 1,558,137.6 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,342,720.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,320,508.4 мянган төгрөг буюу 98 хувийн гүйцэтгэлтэй  
*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| Хөтөлбөр, арга хэмжээ                 | Үзүүлэлт                      | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл   | Зөрүү    | Биелэлт |
|---------------------------------------|-------------------------------|-------------|-------------|----------|---------|
| <b>Улсын төсвөөс санхүүжих</b>        |                               |             |             |          |         |
| 80101                                 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 288,191.9   | 288,191.9   | -        | 100%    |
|                                       |                               | 288,191.9   | 288,191.9   | 0        | 98%     |
| <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b> |                               |             |             |          |         |
| 80101                                 | ОНС                           | 1,269,945.7 | 1,269,945.7 | 1,461.90 | 100%    |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/Мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт  | Гүйцэтгэл  |
|---|-------------------------------------------------|-----------------------------|------------|------------|
| 1 | Шууд гэрээ байгуулах                            | Түлш халаалт                | 156,689.70 | 122,337.20 |
| 2 | Шууд гэрээ байгуулах                            | Гэрэл цахилгаан             | 9,767.20   | 13,719.70  |
| 3 | Шууд гэрээ байгуулах                            | Цэвэр, бохир ус             | 9,129.20   | 9,232.10   |
| 4 | Шууд худалдан авалт                             | Урсгал засвар               | 2,124.00   | 2,124.00   |
| 5 | Шууд худалдан авалт                             | Харилцаа холбооны зардал    | 480.40     | 514.80     |
|   | ДҮН                                             |                             | 178,190.50 | 147,927.80 |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2024 оны 02 дүгээр сарын 11-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 375,500.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 5.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2023 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 1,462,206.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16.4 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албаны 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 503,349.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт  |                  |            |
|-----------------|------------------------|------------------|----------|------------------|------------|
|                 | Тоо                    | Дүн              | Тоо      | Дүн              | Хувь       |
| Зөвлөмж         | 1                      | 503,349.0        | 1        | 503,349.0        | 100        |
| <b>Нийт дүн</b> | <b>1</b>               | <b>503,349.0</b> | <b>1</b> | <b>503,349.0</b> | <b>100</b> |

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,359,3445.0 мянган төгрөгийн алдаа илэрсэнээс 301,586.7 мянган төгрөгийн алдааг залруулж 2,057,858.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

##### 5.1 Зөвлөмж хүргүүлээгүй

##### 5.2 Албан шаардлага

2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,057,858.3 мянган төгрөгийн 13 төрлийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

##### 5.3 Төлбөрийн акт тогтоогоогүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |             | Үүнээс        |     |                 |             |         |     |                                      |                     |                                                 |     |
|----------------------------------------------------------|-------------|-------------|---------------|-----|-----------------|-------------|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                                          |             |             | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |             | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                          | Тоо         | Дүн         | Тоо           | Дүн | Тоо             | Дүн         | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| Хөрөнгийн тооллого хийгээгүй                             | 1           | 1,179,160.4 |               |     | 1               | 1,179,160.4 |         |     | 1                                    | 1,179,160.4         |                                                 |     |
| Бараа материалын тооллого хийгээгүй                      | 1           | 56,171.9    |               |     | 1               | 56,171.9    |         |     | 1                                    | 56,171.9            |                                                 |     |
| Тооцооны үлдэгдлийн баталгаа байхгүй                     | 1           | 314,578.1   |               |     | 1               | 314,578.1   |         |     | 1                                    | 314,578.1           |                                                 |     |
| хөрөнгийн ашиглалтын хугацаа оруулаагүй элэгдэл бодоогүй | 1           | 126,499.9   |               |     | 1               | 126,499.9   |         |     | 1                                    | 126,499.9           |                                                 |     |
| Үр дүнгийн урамшуулал илүү олгосон                       | 1           | 98,737.4    |               |     | 1               | 98,737.4    |         |     | 1                                    | 98,737.4            |                                                 |     |
| Гэрээ анхан шатны баримтгүй                              | 1           | 72,332.9    |               |     | 1               | 72,332.9    |         |     | 1                                    | 72,332.9            |                                                 |     |
| Бараа материалын ангилал буруу авсан                     | 1           | 3,253.0     |               |     | 1               | 3,253.0     |         |     | 1                                    | 3,253.0             |                                                 |     |
| Шатахууны тооцоо бодоогүй                                | 1           | 155,571.5   |               |     | 1               | 155,571.5   |         |     | 1                                    | 155,571.5           |                                                 |     |
| Шатахуун буруу зарцуулсан                                | 1           | 8,194.1     |               |     | 1               | 8,194.1     |         |     | 1                                    | 8,194.1             |                                                 |     |
| Бэлэг дурсгалын зүйл худалдаж авсан                      | 1           | 1,280.0     |               |     | 1               | 1,280.0     |         |     | 1                                    | 1,280.0             |                                                 |     |
| Сэлбэг хэрэгсэл баримт дутуу худалдан авсан              | 1           | 17,447.7    |               |     | 1               | 17,447.7    |         |     | 1                                    | 17,447.7            |                                                 |     |

|                                                              |           |                    |  |  |           |                    |  |  |           |                    |  |  |
|--------------------------------------------------------------|-----------|--------------------|--|--|-----------|--------------------|--|--|-----------|--------------------|--|--|
| Бараа материалын<br>хөдөлгөөний бүртгэл<br>буруу хийсэн      | 1         | 8,031.1            |  |  | 1         | 8,031.1            |  |  | 1         | 8,031.1            |  |  |
| Урсгал засварын зардал<br>үндсэн хөрөнгөнд<br>капиталжуулсан | 1         | 16,600.0           |  |  | 1         | 16,600.0           |  |  | 1         | 16,600.0           |  |  |
| <b>Дүн</b>                                                   | <b>13</b> | <b>2,057,858.3</b> |  |  | <b>13</b> | <b>2,057,858.3</b> |  |  | <b>13</b> | <b>2,057,858.3</b> |  |  |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Д.БАТ-УНДРАА

ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х.БОЛДБААТАР

ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР



Ц.ОЮУНСУВД

ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР



Г.УРАНБАЯР

ОГНОО: 2024-02-22